

АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хуулийн төслийг Монгол Улсын бусад хууль, тогтоомжид нийцүүлж, Засгийн газрын тухай, Төрийн албаны тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулна.

Авлигын эсрэг хууль 2006 онд батлагдан хэрэгжиж эхэлсэн өдрөөс хойш хэрэгжээд 20 жил өнгөрсөн байна.

Гэтэл Transparency International байгууллагаас гаргасан 2025 оны “Авлигын төсөөллийн индекс (CPI)”-ээр Монгол Улс 31 оноо авч, 182 улсаас 124-р байрт орсон нь 2024 онтой харьцуулахад 2 оноо 10 байраар ухарсан үзүүлэлт болж байна.

АТГ-ын үйл ажиллагааны тайланд дурдсанаар 2025 онд авлигын улмаас 674.7 тэрбум төгрөгийн хохирол учирсан нь өмнөх онтой харьцуулахад 61.7%-иар өссөн. Мөн АТГ 1322 гомдол хүлээн авч, 367 хэргийг шүүхэд шилжүүлсэн ч нөхөн төлөгдсөн хохирлын хэмжээ нийт хохирлын ердөө 37% орчим буюу ойролцоогоор 247.8 тэрбум төгрөг, үлдсэн 63% буюу 426.9 тэрбум төгрөг нөхөн төлөгдөөгүй байна.

Дүгнэвэл, Олон улсын байгууллагын үнэлгээгээр сүүлийн 10 жилд Монгол Улс авлигаараа хамгийн муу үзүүлэлтэд хүрч, ард түмний төрд итгэх итгэлийг сулруулж, далд эдийн засгийг тэтгэсэн байна. Эдгээр сөрөг үр дагавар нь авлигатай тэмцэх байгууллагын улстөрийн нөлөөллөөс ангид, хараат бусаар ажиллах үндсэн зарчим хэрэгжихгүй байгаатай холбоотой гэж үзэж байна.

Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь 2 зүйлтэй:

1 дүгээр зүйл. Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийг дараах байдлаар өөрчлөн найруулсугай:

“21 дүгээр зүйл. Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг томилох

21.1. Авлигатай тэмцэх газрын даргыг Улсын Их Хурал 5 нэр дэвшигчээс олонхийн саналаар 6 жилийн хугацаагаар томилно.

21.2. Нэр дэвшигчийг сонгох журам нь дараах байдалтай байна:

21.2.1. Авлигатай тэмцэх газрын даргад нэр дэвшүүлэх ажлыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо зохион байгуулна;

21.2.2. Нэр дэвшигчдийг ил тод, өрсөлдөөнтэйгөөр сонгон шалгаруулж, дор хаяж таван нэр дэвшигчийг Улсын Их Хуралд танилцуулна;

21.2.3. Улсын Их Хурал нэр дэвшигчдийг хэлэлцэж, томилгооны сонсгол хийсний дараа нууц санал хураалтаар олонхийн саналаар (Улсын Их Хурлын гишүүдийн ирцтэй гишүүдийн олонх) нэг нэр дэвшигчийг Авлигатай тэмцэх газрын даргаар томилно;

21.2.4. Нэр дэвшигч нь Авлигын эсрэг хуулийн 19.1-д заасан шаардлагыг хангасан, авлигагүй, ёс зүйн өндөр шаардлага хангасан байх ёстой.

21.3. Авлигатай тэмцэх газрын дэд даргыг Авлигатай тэмцэх газрын даргын санал болгосноор Улсын Их Хурал томилгооны сонсгол хийж 6 жилийн хугацаагаар томилно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУУЛИЙН ТӨСӨЛ САНААЧЛАГЧ